

**Улаанбаатар хотын хүйтний улирлын агаарын чанарын төлөв байдал
/2019 оны 2 дугаар сар/**


Улаанбаатар хотын агаарын чанарыг гэр хороолол, автозам, орон сууцны хороолол, үйлдвэрийн дүүрэг орчмын 15 цэгт агаар бохирдуулах бодис болох хүхэрлэг хий (SO₂), азотын давхар исэл (NO₂), PM2.5, PM10 тоосонцор, нүүрстөрөгчийн дутуу исэл (CO), озон (O₃) болон цаг уурын үзүүлэлтүүдийг автомат багаж болон химийн аргаар тодорхойлж байна.

2019 оны хүйтний улирлын 2 дугаар сарын Улаанбаатар хотын агаар дахь бохирдуулах бодисын дундаж агууламжийг 2018 оны мөн үеийн дундаж агууламжтай харьцуулахад PM10 тоосонцор 18 мкг/м³-ээр буюу 10%-аар их байсан бол PM2.5 тоосонцор 29 мкг/м³-ээр буюу 19%-аар бага, хүхэрлэг хий, азотын давхар исэл өөрчлөлтгүй байлаа.

Бохирдуулах бодисын нэр	Агаарын чанарын стандарт MNS 4585:2016	Дундаж агууламж, мкг/м ³	
	Хүлцэх агууламж, мкг/м ³	2018 оны 2-р сар	2019 оны 2-р сар
PM10 тоосонцор	100	176	194↑
PM2.5 тоосонцор	50	149	120↓
Хүхэрлэг хий, SO ₂	50	49	47↔
Азотын давхар исэл, NO ₂	50	48	48↔

Улаанбаатар хотын сүүлийн жилүүдийн хүйтний улирал дахь гол бохирдуулах бодис тус бүрийн сарын дундаж агууламжийг дараах хэсэгт харуулав.

PM10 тоосонцор




Зураг 1. Хүйтний улирлын PM10 тоосонцорын сарын дундаж агууламж, 2015-2019 он

Улаанбаатар хотын агаар дахь PM10 тоосонцорын 2019 оны 2 дугаар сарын дундаж агууламжийг 2018 оны мөн үетэй харьцуулахад 10%-иар их, Агаарын чанарын стандарт

дахь Хүлцэх агууламж /цаашид АЧС дахь ХА гэх/-тай харьцуулахад 1.9 дахин их байна (Зураг 1).


PM2.5 тоосонцор



Зураг 2. Хүйтний улирлын PM2.5 тоосонцрын сарын дундаж агууламж, 2015-2019 он

Улаанбаатар хотын агаар дахь PM2.5 тоосонцрын 2019 оны 2 дугаар сарын дундаж агууламжийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 19%-иар бага, АЧС дахь ХА-аас 2.4 дахин их байна (Зураг 2).


Хүхэрлэг хий (SO₂)



Зураг 3. Хүйтний улирлын хүхэрлэг хийн сарын дундаж агууламж, 2015-2019 он

Агаар дахь хүхэрлэг хийн 2019 оны 2 дугаар сарын дундаж агууламж 2018 оны мөн үеийн түвшинд, АЧС дахь ХА-аас хэтрээгүй байна (Зураг 3).

Азотын давхар исэл (NO₂)



Зураг 4. Хүйтний улирлын азотын давхар ислийн сарын дундаж агууламж, 2015-2019 он

Агаар дахь азотын давхар ислийн 2019 оны 2 дугаар сарын дундаж агууламжийг 2018 оны үетэй харьцуулахад өөрчлөлтгүй, АЧС дахь ХА-аас хэтрээгүй байна (Зураг 4).

ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР